



Та үнэт эдлэл, үнэт чулуугаар хийсэн бүтээгдэхүүн худалдан авахдаа Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх **ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ, СУРГАЛТАД ХАМРАГДСАН** иргэн, хуулийн этгээдээр үйлчлүүлээрэй.

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ЭТГЭЭДИЙГ ШАЛГАХ:

1. Доорх **QR кодыг уншуулан** тусгай зөвшөөрөлтэй этгээдийн мэдээллийг шалгах боломжтой.



2. Тусгай зөвшөөрөлтэй этгээдийн мэдээлэлтэй Санхүүгийн зохицуулах хорооны [www.frc.mn](http://www.frc.mn) цахим хуудасны "Зохицуулалтын салбар" – "Үнэт металл, үнэт эдлэл" – "Тусгай зөвшөөрөл эзэмшигчид" цэснээс танилцах боломжтой.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь "МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ" хуульд заасны дагуу "Мэдээлэх үүрэгтэй этгээд"-д хамаарах тул тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа эрхэлсэн байж болзошгүй этгээдийн талаарх мэдээллийг [info@frc.mn](mailto:info@frc.mn) цахим шуудан болон доорх утсаар мэдээлнэ үү.

Санхүүгийн зохицуулах хороо

[www.frc.mn](http://www.frc.mn)

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол улс, 15160

**51-262607, 51-262604**



## ИРГЭД, ОЛОН НИЙТИЙН АНХААРАЛД




### ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХУВЬ ХҮН, БАЙГУУЛЛАГААР ҮЙЛЧЛҮҮЛЭХ

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдээр үйлчлүүлэх.



### ЗӨВХӨН ТӨГРӨГӨӨР ХУДАЛДАН АВАЛТ ХИЙХ

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд "Монгол Улсын нутаг дэвсгэрт бараа, ажил, үйлчилгээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх" гэж заасны дагуу гадаад валютаар төлбөр тооцоог гүйцэтгэхгүй, зарлан сурталчлахгүй байх.



Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбар бол олон улсын хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэйд тооцогддог салбаруудын нэг юм.

**ИЙМД САЛБАРЫН ЗОХИЦУУЛАГЧ  
БАЙГУУЛЛАГААС ДАРААХ СЭРЭМЖЛҮҮЛГИЙГ  
ИРГЭД, ОЛОН НИЙТЭД ХҮРГҮҮЛЖ БАЙНА**

☎ 51-262607, 51-262604  
🌐 www.frc.mn  
📍 Санхүүгийн зохицуулах хороо

📍 Засгийн газрын IV байр, Бага тойруу  
3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар  
хот, Монгол улс, 15160

### СОРЬЦЫН БАТАЛГААНЫ ТЭМДГИЙГ ШАЛГАХ

Төрийн эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан "Сорьцын баталгааны тэмдэг"-тэй,



"Эрдэнийн чулууны гэрчилгээ"-тэй үнэт эдлэл худалдан авах.

### ЗАЛИЛАН МЭХЛЭХ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

А. Цахим худалдаанд оролцож, үнэт эдлэл худалдан авахдаа эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, эрдэнийн чулууны гэрчилгээ, сорьцын баталгааны тэмдгийг тулган шалгах.



Б. Иргэдийн гар дээрээс үнэт эдлэл худалдан авахгүй байх.